



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/330

Номгон


Нэмэлт өөрчлөлт оруулж, зорчигч,
тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт
тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Улсын Онцгой комиссын 2021 оны 46 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 44 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны “гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/291 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөгдсөн салбар, байгууллагуудын жагсаалт” хэсэгт спорт заал, фитнес клубуудын үйл ажиллагааг нэмж, уг захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хязгаарлалт тогтоосон байгууллага, аж ахуй нэгжүүдийн жагсаалт” хэсгийн 11 дүгээр заалт (11. Чийрэгжүүлэх, бялдаржуулах төвүүд)-ыг хассугай.

2. Хөдөлгөөний хязгаарлалтыг нээсэнтэй холбогдуулан аймаг, хот хооронд зорчих зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд Улсын Онцгой комиссын 2021 оны 46 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын дагуу хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Авто тээврийн төв (С.Амармөнх)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН